**Төвийн эрхэм зорилго:**
Зэвсэглэл, техник, материал хэрэгслийн талаарх харьцуулсан судалгаа хийж, vйлдвэрлэлд нэвтрvvлэх боломжийг судалж, инновацийг хогжvvлэх.



**Үйл ажиллагааны зорилго:**
Гадаад орнуудын зэвсэгт тэмцлийн хэрэгслийн харьцуулалт, Зэвсэгт хvчний зэвсэглэл, техник, хэрэгслийг зохион бvтээх, vйлдвэрлэх, сайжруулах, технологи нутагшуулах талаар судалгаа, туршилт явуулж, инновацийг хогжvvлэх.

**Үйл ажиллагааны гол зорилт:**

- Гадаад орнуудын зэвсэглэл, техник, технологид харьцуулсан судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Зэвсэгт хvчний зэвсэглэл, техник, материал хэрэгслийн чанар байдлыг судалж, сэргээн сайжруулах санал зовломж боловсруулах;
- Зэвсэгт хvчинд инноваци, ондор технологийг нэвтрvvлэх судалгаа явуулах;
- Зэвсэглэл, техник зохион бvтээх, vйлдвэрлэх талаар судалгаа явуулж, батлан хамгаалах аж vйлдвэрийг хогжvvлэх санал боловсруулах.

**Тvvхэн замнал**
1995 онд Цэргийн эрдэм шинжилгээний хvрээлэнгийн дэргэд “Эртний монгол цэргийн зэвсэг”-ийн талаар судалгаа хийх орон тооны бус хамтлаг байгуулагдсанаар vйл

ажиллагааны эхлэл тавигдсан.
1997 онд хvрээлэнгийн харъяанд “Туршилт зохион бvтээх тов” байгуулагдаж товийн даргаар хурандаа Г.Гvрбазар томилогдон таван хvний бvрэлдэхvvнтэй ажиллаж эхэлсэн.

2009 оноос “Инновацийн тов”, 2010 оноос “Зэвсэг техник, инноваци судлалын тов”, 2016 оноос **“Байлдааны зэвсэглэл, техник, технологи судлал, инновацийн төв”** нэртэйгээр vйл ажиллагаагаа явуулж байна.

Тус тов нь эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт зохион бvтээх нийт 41 тосолт ажил гvйцэтгэсэн. Монгол Улсын Засгийн газрын захиалгатай 3 тосол, Батлан хамгаалах яамны захиалгатай 18 тосол, Зэвсэгт хvчний жанжин штабын захиалгатай 8 тосол, сургууль, хvрээлэнгийн дотоодын толовлогоот 12 ажлыг амжилттай гvйцэтгэсэн байна.

Товийн ажилтнууд 22 бvтээлийн загвар, 14 технологи боловсруулж туршилт, vйлдвэрлэл явуулан 50,0 сая тогрогийг орлого оруулсан.

1997, 2006, 2007, 2009, 2011 онуудад сургууль, хvрээлэнгийн тэргvvний товоор шалгарч байсан.
Товийн ажилтнууд дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээ, онол практикийн хурлуудад 8 илтгэл хэлэлцvvлж 16 огvvлэл, 10 хамтын бvтээл хэвлvvлсэн.

Товийн хоёр бvтээл Монгол Улсын оюуны омчийн газарт зохиогчийн эрхийн хамгаалалт хийсэн.
Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээний шилдэг бvтээл шалгаруулах уралдаанд техник технологийн чиглэлээр 5 бvтээл шалгарч тэргvvн байр эзэлсэн. ЗХЖШ-аас зарласан ШБОС-ын уралдаанд 2 бvтээл тусгай байрын шагнал хvртсэн.